



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, 110 дугаар зүйлийн 110.1, 110.2 тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдын ээлжийн амралтын цалинг 1.5 хувиар нэмэгдүүлэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д зөвшөөрсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлтийн ерөнхий менежер (Б.Золбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л. Дэлгэр
Л.ДЭЛГЭР





**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.1.3, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.5, газрын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.1, 6.4.4, газрын даргын 2020 оны А/32 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт байгууллагын “Хөдөлмөрийн аварга” шалгаруулах журам, газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2023 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн үйлчилгээний чанар стандартыг сайжруулахад хөдөлмөр, ур чадвар, идэвх зүтгэл гарган хамт олноо манлайлан ажиллаж байгууллагын “Хөдөлмөрийн аварга”-аар шалгарсан хавсралтад заасан нэр бүхий ажилтан, албан хаагчдад зарцуулагдах зардлыг нэг удаагийн тэтгэмжийн зардлаас олгохыг Ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д зөвшөөрсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлтийн ерөнхий менежер (Б.Золбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Л. Дү* Л.ДЭЛГЭР





**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар A/60

Улаанбаатар хот

**Ур чадварын
нэмэгдэл олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, газрын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 07 дугаар зөвлөмжийн 8 дугаар заалт, газрын даргын 2023 оны A/16 дугаар “Журам батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ажилтан, албан хаагчдын 2023 оны 12 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг хавсралтад заасан ажилтан, албан хаагчдад олгосугай.

2.Ур чадварын нэмэгдлийг ажилтан, албан хаагчийн үндсэн цалингаас нь хавсралтад заасан хувь хэмжээгээр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Золбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.Дэлгэр Л.ДЭЛГЭР





**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар A/61

Улаанбаатар хот

Үр дүнгийн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16.5, 16.5.5, Төрийн албан тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, 51.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 123.1, 145.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2, 1.2.2, 2.1, 2.2, 2.3, 2.5, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоол, газрын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.1, 6.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ажилтан, албан хаагчдын 2023 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Төрийн албан хаагчийн ажлын үр дүнг үндэслэн хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн, хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй хавсралтад нэр заасан ажилтан, албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосугай.

3.Мөнгөн урамшуулалыг ажилтан, албан хаагчдын үндсэн цалингаас хавсралтад заасан хувь хэмжээгээр тооцож цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас олгохыг Ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

(Handwritten signature)
Л.ДЭЛГЭР





**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар A/62

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, газрын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тогооч нарын мэргэжил ур чадварыг дээшлүүлж мэдлэг олгох сургалтыг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулахтай холбогдуулан сургалтад шаардагдах 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн зардлыг сургалтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д зөвшөөрсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлтийн ерөнхий менежер (Б.Золбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  ДЭЛГЭР





НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 1/63

Улаанбаатар хот

Ажилтан, албан хаагчдад урамшуулал
олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 46 дугаар зүйлийн 46.3.2, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар хуралдааны тэмдэглэл, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтан, албан хаагчдын 2023 оны ажлын гүйцэтгэл, үр дүнг нь харгалзан үзэж мөнгөн урамшуулал олгох хувийг хавсралтаар баталсугай.

2. Мөнгөн урамшуулалыг ажилтан, албан хаагчдын үндсэн цалингаас хавсралтад заасан хувь хэмжээгээр тооцон цалин хөлс, нэмэгдэл урамшуулалын зардлаас олгохыг Ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлтийн ерөнхий менежер (Б.Золбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л. ДЭДГЭР





**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Аж ахуйн материал актлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.1.2 дахь хэсэг, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын жилийн эцсийн тооллогоор үүссэн аж ахуйн материал дансанд бүртгэлтэй байгаа хавсралтад дурдсан 46,587,927 (Дөчин зургаан сая таван зуун наян долоон мянга есөн зуун хоорин долоо) төгрөгийн аж ахуйн материалуудыг акталж данснаас хассугай.

2.Данс бүртгэлээс хасагдсан аж ахуйн материалыг актлах ажлыг холбогдох хууль журмын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохион байгуулж, дүнг танилцуулахыг ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *M. My* Л.ДӨЛГЭР



134
135



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот


Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах” тухай 66 дугаар тогтоолын 3.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай дараах нэр төрлийн 23,450,000 (Хорин гурван сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг данс бүртгэлд зохих журмын дагуу бүртгэх ажлыг зохион байгуулан, хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (М.Мөнхтулга)-д үүрэг болгосугай

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, Төлөвлөлтийн ерөнхий менежер (Б.Золбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л. ДЭЛГЭР



C:\Users\Desktop\A tushaal.docx

1150500129

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2023 оны 12 дугаар сарын 23 ны
өдрийн 11/6 дугаар тушаалын хавсралт



Хөрөнгийн жагсаалт

№	Нэр	Н.Б.Үнэ	Х.Нэгж	Бүрт.дуг	Тоо	Дүн
1	Хэрэгцээний халуун усны ялтсан бойлер	2,860,000	ш	13535	1	2,860,000
2	Бохирын ганом насос	3,040,000	ш	13361	2	6,080,000
3	Халуун хөшиг 180 см	2,300,000	ш	13386	2	4,600,000
4	Халуун хөшиг 150 см	1,650,000	ш	13387	2	3,300,000
5	380V 30квт тень	1,500,000	ш	13560	2	3,000,000
6	Халуун хөшиг 120см	1,485,000	ш	13559	1	1,485,000
7	Гадна камер	132,000	ш	8958	9	1,188,000
8	Дотор камер	93,700	ш	8957	10	937,000
		13,060,700			29	23,450,000